



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 49

Хэрлэн сум

Бэрх хотын Захирагчийн ажлын албаны
Хүнс, жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал
хариуцсан мэргэжилтний сул орон тоонд
томилуулахаар нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо (62,3) авсан Шаравсамбуугийн Ганцэцэгийг Бэрх хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшигч Ш.Ганцэцэгийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Бэрх хотын Захирагчийн ажлын албаны дарга (Э.Мягмарсүрэн)-д зөвлөсүгэй.

3.Энэхүү тогтоолыг Бэрх хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА